

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Сайнцагаан сумын Үйзэн багийн засаг дарга	Дугаар	L350
Оршин суугаа аймаг	Дундговь аймаг	Оршин суугаа сум	Сайнцагаан сумын Үйзэн баг
Төрсөн газар	Сайнцагаан сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Үйзэн багийн засаг дарга		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хорин хийд	Сүм хийдийн дугаар	ДУСЦ 048
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-рсарын 20	Ярилцлага авсан хүн	Жужа



Дундговь аймгийн Сайнцагаан сумын Хорин хийд

Жужа: Энэ Хорин хийд хэзээ байгуулагдсан, хэн байгуулсан талаар хэлнэ үү?

Засаг дарга: За миний бодож байгаагаар 1800 хэдэн онд байгуулагдсан байх. Заваа Дамдин багшийн номын багш Төвдийн Брайвүн хийдэд олон жил ном үзсэн Лувсанбалдансанжаажав гэж гүн ухаан судалсан том лам олон түмэндээ ач ивээлтэй, олон ном бүтээл бичсэн эрдэмтэй хүн байсан. Энэ хүн санжаажав гэж олондоо алдаршсан. Энэ хүн Хорин хийдийн шавыг нь тавьж, дараа нь төвд багш гэж төвд хүн тэргүүлж байгаад энэ хүний дараа Жигмэд хувилгаан гэдэг хүн тэргүүн лам нь байсан. Жигмэд хувилгаан ардын засгийн үед баригдаж цаазлагдсан юм билээ. Энэ бол үнэн юм билээ. Лувсанбалдансанжаажав гэдэг хүн Заваа Дамдиныг таван настайгаас нь эхлэн ном зааж чойрын гүн ухаан зааж эхэлсэн юм гэдэг. Ийм л түүх байдаг юм байна лээ.

Жужа: Хорин хийдийн өөр нэр?

Засаг дарга: Хорин хийдийн одоо балгас нь бол байгаа. Гол төв балгас нь бол байгаа. Бусад нь туурь болоод өнгөрсөн. Тэгээд цагийн өөрөө урсгалаар эдвэрч, сүм орон нутагт ч тэгээд хөрөнгө мөнгө байхгүй олдоггүй учир засварлаж чаддаггүй юм аа.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Гучин долоон оноос хойш энэ дугангыг юунд хэрэглэж байсан бэ?

Засаг дарга: Ер нь гучин долоон оноос хойш нэг хэсэг скалад байж байгаад тэгээд сүүлдээ эзэнгүй болсон доо.

Жужа: Рашаан үс?

Засаг дарга: Лам нар уудаг амны үс байдаг, мал уудаг бас нэг үс байдаг. Амны үс нь байхгүй болчихоор нь дахин сэргээсэн.

Жужа: Тахидаг үүл овоо?

Засаг дарга: Аа энд Хүүхдийн цагаан овоо, дээр үедээ бол энэ Хүүхдийн цагаан овоо гэж хол ойроос асар олон хүн цуглаж хүүхэд баярлуулж наадам хийдэг байсан. Цагаан овоо энүүхэн зүүн хойно хоёр км-т байдаг юм. Бас км хагасын зайтай баруун хойно нь жинхэнэ тахидаг үүл нь байдаг юм, Тахилгат гээд.Тэгээд тэр Тахилгатынхаа За тэр үедээ Дайчин бэйсийн Даллаганы сав гэгдэж байсан хөдөлдөг хад, монгол улсын соёлын том хоёр бүртгэлтэй хад байдаг юм, нэг нь бол энд байгаа. Хэвтэж байгаа тэмээнээс арай том тийм хад байдаг. Тэгээд энийгээ 2006 онд нутгийн настангууд, компанийн захирлууд нийлээд тоногдонд нь краанар ингэж тоноглож байгаа юм болсон. Тэгээд хичнээн жил хөдлөөгүй хад гараар түлэхээд л хөдөлдөг гэж байгаа. Тэгээд энийгээ бас тахиx санаатай байгаа. Энэ урлшаагаа Өнгөт гэж өндөр хайрхан байдаг. Энэ Хайрханд зориулж тэр Усан мандлын сангийн аж ахуйг барьснаас хойш Төвд багш байж байгаад хайрханд зориулж шүтдэг тийм лус бурхан бүтээсэн. Уг нь бол тахиx шүтдэг байсан, сүүлийн үед байхгүй болсон. Тэгээд Тахилгат, энэ Хүүхдийн цагаан овоо ойрхон байдаг болоод тахидаг байсан юм шиг байгаа юм. Тэр хойд талын Хонгорын уулын овоон дээр гарч нутгийн малчин ардууд өвөлжилт ган зуд гээд цаг уураа шинждэг, тэнгэр харж шинждэг уламжлалтай. Иймэрхүү түүхтэй.

Жужа: Хорин хийдийн түүхээс хэдэн ламтай, хэдэн дугантай байсан талаар та ярьж өгнө үү?

Засаг дарга: За нэг 40, 50-иад ламтай, олон жижиг шавар байшинтай ийм хийд байсан. жижиг байшингууд тэр дуганы тууриуд байсныг өмнөх засгийн үед шатаагаад түрээд устгаад юу ч үгүй болсон. Шажин номыг хурааж байх үед бурхан тахил ном судрыг нь арван хэдэн хүн үхэр тэргээр урагш нь нэг газар шатаагаад булсан гэдэг. Түүнийг малд явж байсан нутгийн нэг залуу хараад очмогц малчин залууг нөгөө хүмүүс барьж аваад Улаанбаатарт аваачиж шоронд хийгээд гаргасан гэнэ лээ. Тэгээд тэр залуу нутагтаа дахиж ирэлгүй хотод байж байгаад өнгөрсөн дөө. Би Хорин хийдийн түүхийг судлах мэдээ баримт олж цуглуулах талаар хөөцөлддөг юм. Ер нь их ховор доо. Манай ээжийн ах лам хүн байж байгаад Төвд багштайгаа цуг бас Найдан гэдэг ламтай хамт эрт үед Төвд рүү гараад ууланд даянч хийж байгаад сурраггүй болсон гэдэг.

Жужа: Энэ хийд хэдэн онд хаагдсан бэ?

Засаг дарга: Гучин хэдэн онд л хаагдсан гэдэг.

Жужа: Энэ хийдэд шавилж сууж байгаа лам одоо бий юу?

Засаг дарга: Юу ч байхгүй. Харин манай нутгийн арваад настай хоёр хүүхэд хойно энэ/ Улаанбаатарыг хэлэв бололтой / шашны сургуульд сурч байгаа. Тэр хоёр чухам хэт ирээдүйдээ эндээ ирэх юм үү яах юм , мэдэхгүй.

Жужа: Энэ бригад хэдэн онд эзгүй болсон бэ?

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Засаг дарга: Уг нь энэ дээр айлүүд байдаг байсан юм. 2000 оноос хойш эзгүйрсэн, манай нутагт чинь одоо ган зуд болоод олон жил айл өрх нүүдэллэн явах болсон, тэгээд эзгүйрсэн. Би чинь одоо эзгүй газар байлтай нь биш, төв хөдөө хоёрын хооронд л явж байна. Уг нь одоо сарын дараа энд байнгын сахиул айлтай болох юм.

Жужа: Яг энэ хийдийн лам нарыг та мэдэх үү?

Засаг дарга: Би яг одоо мэдэхгүй байна. Уг нь надад сууж байсан лам нарын нэрсийг бичсэн жагсаалт бий. Юмаа ухвал гарах байх. Одоо энд алга. Ер нь Заваа Дамдин багшийн түүх намтартай холбоотой ном бичгүүд дээр энэ Хорин хийдийн тухай бас мэдээ байдаг юм.

Жужа: Их баярлалаа.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон